

МОНГОЛЫН АНУ СУДЛАЛЫН ТӨВ
MONGOLIAN CENTER OF U.S. STUDIES

АМЕРИКА
Судалгаа, мэдээлэл
АМЕРИКА
Studies and Information

АМЕРИК:

Судалгаа, мэдээлэл

AMERICA:

Studies and Information

Улаанбаатар
Ulaanbaatar

1994 No.1(1)

МОНГОЛЫН АНУ СУДЛАЛЫН ТӨВ

Монгол-Америкийн
Нийгэмлэг

Монголын ШУА-ийн Дорно-
дахин, олон улс судлалын
хүрээлэн

МУҮИС-ийн Олон улсын
харилцааны дээд
сургууль

АМЕРИК: Судалгаа, мэдээлэл

(Шинжлэх ухаан, сурталчилгаа, мэдээллийн сэтгүүл)

Жилд 2 удаа гарна.

358 -

1994

Улаанбаатар
Монгол улс

№1 (1)

Редакцийн зөвлөл:

Эрхлэгч Н.Ишжамц (профессор, академич)
Орлогч эрхлэгч Ц.Батбаяр (дэд эрдэмтэн)

Гишүүд: Ц.Пунцагноров (академич)
С.Ишдорж (дэд эрдэмтэн)
Д.Алтангэрэл
Ж.Баясах (дэд эрдэмтэн)
Г.Нямдоо (дэд эрдэмтэн)
Л.Маналжав (дэд эрдэмтэн)
А. Кампи (доктор)
Ц.Сумьяа (дэд эрдэмтэн)
Д.Цолмон (дэд эрдэмтэн)
Н.Энхбаяр (Соёлын сайд)

Нарийн бичгийн
дарга нар: М. Хурметхан (дэд эрдэмтэн)
Д.Баярсайхан
С.Ганболд

Редакцийн хаяг: Монголын АНУ судлалын төв,
шуудангийн 46-р салбар,
ш.х 320, Улаанбаатар, Монгол улс

Улаанбаатар

MONGOLIAN CENTER OF U.S. STUDIES

**Mongol-American
Society**

**Institute of Oriental
and International
Studies, Mongolian
Academy of Sciences**

**School of Foreign
Service, Mongolian
State National
University**

AMERICA : Studies and Information

(Scientific, popular and information semi-annual magazine)

1994

**Ulaanbaatar
MONGOLIA**

No 1 (1)

Editorial Council :

N.Ishjanta (Prof. Academician, Editor-in-chief)

Ts.Batbayar (Dr. Deputy Editor-in-Chief)

Ts.Puntegnorov (Academician)

S.Ishdorj (Dr.)

B.Altangerel

J.Bayasakh (Dr.)

G.Niamdoo (Dr.)

L.Manaljav (Dr.)

Alisa Campi (Dr.)

D.Tsoimon (Dr.)

Ts. Sumya (Dr.)

N.Enkhbayar (Minister of Culture)

Staff Members:

M.Khurmetkhan (Dr.)

D.Bayarsaikhan

S.Ganbold

Editorial Address:

Mongolian Center of U.S. Studies,

P.O.Box : 46/320

Ulaanbaatar MONGOLIA

Printing House, Mongolian Ministry of Culture

ӨМНӨХ ҮГ

Монголын АНУ судлалын төв нь Монгол-Америкийн нийгэмлэг, Монголын Шинжлэх Ухааны Академийн Дорнодахин, Олон улс судлалын хүрээлэн, Монгол Улсын Үндэсний Их Сургуулийн Олон улсын Харилцааны Дээд сургуультай хамтран манай оронд Америк судлалыг хөгжүүлэх, Монгол-Америкийн найрамдал, хамтын ажиллагаанд тус дөхөм үзүүлэх, Монголын олон нийтийг дэлхийн тэргүүний хөгжил бүхий "Америкийн Нэгдсэн улстай ямар нэгэн хэмжээгээр танилцуулах зорилгоор шинжлэх ухаан, сурталчилгаа, мэдээллийн хагас жил тутмын "Америк: судалгаа, мэдээлэл хэмээх нэртэй сэтгүүлийг олон түмэн уншигчдаа өргөн барьж байна" Энэхүү сэтгүүлийн гол өгүүлүүдээр англи товчлол (резюме) байх болно.

Манай орон дахь АНУ судлалд хувь нэмрээ оруулахыг хүссэн мэргэн уншигч таныг үнэ цэнтэй санал, зөвлөлгөөгөө бидэнд ирүүлж бидний ажилд тус дэм үзүүлнэ гэдэгт итгэнэм.

Редакцийн зөвлөл

Preface

Mongolian Center of U.S. Studies together with Mongol-American Society and with Institute of Oriental and International Studies, Mongolian Academy of Sciences, and with School of Foreign Service, Mongolian State University in the purpose of developing American studies in our country and promoting Mongol-American friendship and cooperation and introducing at any extend the Mongolian public to the United States of America, the most advanced country in the world, for the first time offers many readers semi-annual scientific-popular and information magazine, which assumes the name "America: Studies and Information". There will be also contained English summaries of chief articles in the magazine.

We believe that you, wise readers, will send us your impressions on this magazine and your valuable proposals and advices on the problems of U.S. Studies in Mongolia.

Editorial Council

МОНГОЛ ДАХЬ АМЕРИК СУДЛАЛЫН ГАРАА

Профессор, академич Н.Ишжамц
(Монголын АНУ судлалын төвийн тэргүүн)

"Аль долоон зуун жилийн тэртээ Их хаадын байлдан дагуулал, ноёрхлын үед Монгол улс нь Евро-Азийн өргөн уудам тивд улс түмний харилцаа, үзэл бодол, засаглалын зарим уулзвар дээр байсан билээ. Гэтэл энэ зууны дунд үед Монгол нь Москва, Бээжингийн хоорондох зам дээр сталинч харуулын газар болж байлаа. Тэгвэл өнөөдөр Монгол нь огт өөр утгаар өөрийгөө Ази болон даян дэлхийд ардчиллын үнэт зүйлс чөлөөт зах зээлд тулгуурласан шинэ журмын замын уулзвар дээр аваачиж тавилаа. Та нар коммунизмыг талархаж хүлээн авсан Азийн анхны орон билээ. Одоо та нар ардчиллыг сонгож авч байгаа Азийн анхны орон болж байна" (АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан Ж.Бейкер Монголд ирээд хэлсэн үгнээс)

XIX зууны эцэс, XX зууны эхэн үеэс АНУ шинжлэх ухаан-Техник, эдийн засаг, соёлын талаар эрчимтэй хөгжиж, дэлхийн П дайнд фашизмыг ялах явдалд жинтэй хувь нэмэр оруулаад ардчилал, хүний эрх, нийгмийн эрх чөлөөг хөгжүүлэх үйл хэргийг манлайлагч хэт их гүрэн болсон явдал олон улсын анхаарал сонирхлыг татаж, Америкийн амьдрал, хөгжил, дотоод гадаад бодлогын талаар тусгайлан шинжилгээ хийдэг америк судлал хэмээх шинжлэх ухааны шинжлэх салбар (АНУ-даа 30-аад оноос) бий болсон байна. Баруун Европ, Япон, Орос, Хятад, Энэтхэг зэрэг улс оронд америкийн судлал хүчтэй хөгжиж, Латин Америк, Австрали, Ази, Африкийн бусад улс орон цөм өөрийн гэсэн америк судлалтай болжээ. Сүүлийн үед хүртэл америк судлалгүй явж ирсэн улс манайхаас өөр бараг ганц ч байсангүй бололтой.

Гэтэл дэлхийн бөмбөрцгийн зүүн, баруун хязгаарт хамгийн хол алслаг оршдог, тэс өөр амьдрал ахуйтай Монгол, Америк хоёр орны улс түмэн XIX зууны дунд үеэс бие биенийг мэдэх, сонирхох болж, XX зуунд эсрэг, тэсрэг үзэл суртлын хүлээсэнд автсан байхдаа ч авжмаар харилцан ойлголцох болсоор өөрчлөлт шинэчлэлтийн үүрийн туяа тусмагц 1987 оны эхээр албан ёсны дипломат харилцаа тогтоож, бүрэн эрхт элчин сайдын

ямаа тус тусын нийслэлд нээсэн билээ. 1989-90 оны үеэс Монголд ардчилал, олон намын тогтолцоо, чөлөөт зах зээлд орох шилжилт эхлэхийн хамт Монгол, Америкийн нийгэмлэг байгуулагдаж, дараа нь АНУ-д Америк, Монголын нийгэмлэг байгуулагдан, тус хоёр орны харилцаа холбоог өргөтгөж, хамтын ажиллагаа өрнүүлэхэд тус дөхөм болох зорилт тавьж ажиллаж байна. 1991 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Америкийн ерөнхийлөгчийн урилгаар Монгол улсын ерөнхийлөгч П.Очирбатыг АНУ-д айлчлалаа эхэлсэн өдрийг тохиолдуулан ШУА-ийн Дорно Дахин, олон улс судлалын хүрээлэнгийн дэргэд Монголын АНУ судлалын төв анх байгуулагдсан юм. Тус төвийн зорилго бол манай улсын хөгжил байдалд шууд холбогдон сонирхогдох Монгол, Америкийн хамтын ажиллагаа, АНУ ба Төв, Зүүн хойд Азийн улс орны харилцаа, Америкийн гадаад, дотоод бодлогын зарим асуудал, ардчилал, зах зээл, хүний эрх, хууль цааз, шинжлэх ухаан, соёл, урлагынх нь зарим асуудлыг шинжлэн судалж, Америкийн амьдрал, хөгжлийн тэргүүн туршлагаас чухам юуг хэрхэн яаж бүтээлчээр тусган хэрэглэх зэрэг дээр анхаарч, улс орны хөгжилд эрдмийн бүтээл, практик санал зөвлөмжөөр дөхмийг үзүүлэх явдал юм. Олон түмний дунд Америкийн тухай үнэн зөв мэдлэг дэлгэрүүлж, олон жилийн турш өгөгдсөн гаж буруу ойлголтыг засаж залруулах, шинэ сэргэг мэдээлэл өгөх, англи хэлний сургалт явуулах, шинэ залуу боловсон хүчин бэлдэхэд идэвхтэй оролцох асуудал ч бас төвийн зорилтонд хамаарч буй. Гадаад орон судлалын мэргэжилтэн арвингүй өнөө үед Монгол улс ба АНУ-ын аль алинд холбогдох зарим сонин зүйл Умард, Өмнөд Америкийн бусад улс оронд байдгийг сонирхож судлах ажилд ч гэсэн манай төвд огт оролцохгүй, тойрч өнгөрч хараахан болохгүй биз ээ. Гэвч энэ бүх асуудлын ихээхэн хэсэг нь эрдэм шинжилгээний бусад байгууллага, орон тус бүрийн талаар шинжлэх ухаан, практикийн өргөн мэдлэг чадвар бүхий хувь хүмүүсийн хүчээр хийгдэж ирсэн уламжлал бий, түүнд түшиглэх, хамтарч ажиллах боломж байгаа юм.

Америк судлалыг уг нь АНУ-тай газар дээр нь биечлэн танилцаж судалгаа сурвалжлага хийх, америк гарвалт анхдагч эх сурвалж голлон ашиглаж, тэрхүү орны эрдэмтэн мэргэдээс шууд суралцаж аргаар явуулах нь чухал. Гэвч бусад улс орны америк судлалын ололт амжилтыг бас ашиглаж хэрэглэхээс татгалзах учир үгүй. Судалгааны аргазүйн үүднээс аль алийг зөв зохистой хослуулаж хэрэглэх нь зүйтэй болов уу.

АНУ-ын талаар манай хэвлэлд гарч байгаа зүйлийн заримд нь хэрэв Монгол улс Америктай хэт өргөн харилцаж, их ойртвол эрхшээл нөлөөнд нь орж, яваандаа колоничлогдоно гэсэн айдас болгоомжлол цухалцаж байна. Заримд нь болохоор Америктай аль болохоор ойртож, нэг муж улс нь болчихвол амьдрал амархан сайжирч, түргэн хөгжөөд бие даасан байдлаа хэрэг дээрээ алдахгүй л гэнэ. Урьд Америкийг империализмын үүр уурхай гэж хурц шүүмжилдэг байснаа одоо болохоор цорын ганц найдвартай түшиг

4 гэх шиг. Зөвхөн үүнээс үзсэн ч манайд америк судлалыг эрхбиш үүсгэж, нэлээд эрчимтэй хөгжүүлэх шаардлагатай байгаа биз дээ. Хэвлэлд гарч байгаа зүйлийн дийлэнх ихэнх нь үнэн зөв магадлалтай үзэгдэвч өөрийн гэсэн мэргэжлийн судалгаа, үндэстний боловсон хүчинтэй болох явдал америк судлалын аймагт гарцаагүй хэрэгтэй үзэгдэнэ.

Монголын АНУ судлалын төвийн ажлын гараа ид эхлээд байсан 1991 оны 5 дугаар сард Бээжин хотноо "XX зууны АНУ ба Ази, Номхон далайн бүс нутаг" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал болж, түүнд Америкийн Азийн фонд, түүний Зүүн хойд Азийн сэлбарын захирал Ш.Р.Севе ринхаус манай төвийн төлөөлөгчдийг урьж оролцуулан, байнгын харилцаа холбоо тогтоож, улмаар америк судлалын сурвалж материал, шинжилгээ судалгааны ном зохиол, сургалт сурталчилгааны зарим чухал хэрэглэгдэхүүн ирүүлж дэмжих болсон нь бидний ажилд ихээхэн тус болж байгааг сэтгэл ханамжтай тэмдэглэж, гүн талархал илэрхийлж байна.

1992 он гэхэд Америк тивийг нийт хүн төрөлхтний иргэншилт соёл, шинжлэх ухааны өмнө анх Колумба нээсний 500 жилийн ой, Монгол, Америкийн хооронд дипломат харилцаа байгуулагдсаны 5 жилийн ой, Монголд анхны ардчилсан Үндсэн хууль батлагдах зэрэг түүхэн үйл явдлуудтай давхцсан жил байв. Монголын АНУ судлалын төвийн гишүүд сэтгүүл, сонинд судалгаа, сурталчилгааны өгүүлэл бичиж нийтлүүлэн "Монгол, Америкийн харилцаа", "Америкийн ардчилал, сонгуулийн зарим асуудал" сэдвүүдэд болон Америкийг нээсний ойд зориулсан эрдэм шинжилгээний семинаруудыг Гадаад харилцааны яам, хуулийн байгууллагын харилцаатай ажилтан нар, зарим америк мэргэжилтний оролцоотой зохиож явуулсан юм. Америкийг нээсний ойн семинар дээр илтгэл тавьж, үг хэлсэн монгол, америк эрдэмтэд Монголын эзэнт гүрэн мөхсний дараа феодалын дайн дажны улмаас дорно, өрний хоорондох Торгоны их зам зэрэг хуурай замын тээвэр тасалдаж, аль аль тал нь далайгаар харилцах боломж хайхад Монголын түүхтэй уялдсан сонин зүйл гарч байсан зэргийг олзуурхан тэмдэглэж байв. Дэлхий бөөрөнхий гэдэгт бат итгэж байсан Колумба Хувилай хааны үеийн Монгол, Хятад, Япон, Энэтхэг зэрэг өлс дорнодын баян тансаг улс орнуудын тухай Марка Пологийн замын тэмдэглэлтэй танилцаад баруун зүг далайгаар аялсаар тэдгээр улс орны зүүн талаас нь хүрч очихоор санаа зориг шулуудан хөдөлжээ. Үнэхээр тэгэж америкийн зүүн эрэгт буусан Колумба анх Энэтхэгт очлоо гэж бодод цаана нь Хувилай хааны төр барьж байсан нийслэл Ханбалиг хот асар холгүй байх ёстой гэж үзэж түүнийг эрүүлж суруулж байжээ. Баруун Европын далайч жуулчин бүхэл бүтэн шинэ тив-Америкийг нээхэд Хувилай хааны нэр, Монгол гүрний тухай мэдээ сэлт тийнхүү тохиолдон холбогдсон ажээ.

Америк судлалын талаар Монголын АНУ судлалын төвийн гишүүд, түүнтэй холбоо барьж, хамтран ажилладаг бусад зарим эрдэмтдийн бичиж нийтлүүлсэн зүйлээс нэн түрүү тус төвийн дэд тэргүүн, түүхийн ухааны дэд

эрдэмтэн Ц.Батбаярын "АНУ-ын Азийн бодлого" (Дорно,Өрнө сэтгүүл 1991, Ио 4), "Олон улсын харилцааны хөгжлийн хандлагууд" (мөн сэтгүүл 1992, Ио 1), дэд эрдэмтэн Г.Төмөрчулууны "Шинэ орчим, шинэ бодлого" (мөн тэнд) зэргийг дурдаж болно. Батбаяр ХХ зууны АНУ-ын гадаад бодлогыг Ази тивийн хувьд төдийлөн анхаарахгүй байсан 1941 он хүртэлх үе, цэрэг-Стратегид, үзэл суртлын хүчин зүйлээр тодорхойлогдож байсан 1941-1973 оны хоорондох дэлхийн II дайн, "Хүйтэн дайн"-ны үе, эдийн засгийн асуудал цэрэг-стратегийн хүчин зүйлээс давамгайлах болсон 1973 оноос хойших үе хэмээн үечлэх баримтлалын үндсэн санааг тодруулан дэмжжээ. 90-ээд оны туршид АНУ Азийн улс орнууд, түүний дотор мөн манай Монгол улстай харилцахдаа худалдаа эдийн засгийн асуудал дээр голлон анхаарч ардчилал, хүний эрхийг хэрхэн хангаж байгаатай холбож үзэх хандлагатай байх болно. Дэлхийн II дайны дараа бүрдсэн Америк, Зөвлөлт гэсэн хэт их гүрнүүдийн сөргөлдөөнөөр тодорхойлогдогч олон улсын харилцааны хоёр туйлт тогтолцоо халаагаа өгч, шинэ тогтолцоонд шилжиж байна, хоёр хэт их гүрний алинд нь ч гэсэн, ялангуяа ЗХУ-д зэвсгээр хөөцөлдөх боломж шаахагдсан, одоо үед тэдгээр улс гүрэн хоёр талын харилцааг тус тусдаа сайжруулж, хамтран ажиллах тал нь давамгайлах хандлагатай болов гэсэн дүн шинжилгээ хийсэн байна.

Г.Төмөрчулуун өгүүлэлдээ өнгөрсөн хугацаанд Монгол-Америкийн харилцаа, хамтын ажиллагааны улс төр, эрхзүйн үндэс тавигдлаа, одоо тус хоёр орны хамтын ажиллагааны шинэ арга хэлбэр, эх үүсвэрийг эрж сүвэгчлэх, ялангуяа АНУ-ын хөрөнгө оруулах чиглэлд онц анхаарах нь нэн чухал, ардчилсан Монголын ирээдүйг АНУ үгүйгээр төсөөлөхөд бэрх, дэлхийн бодлогын том, жижиг ямар ч асуудлыг АНУ-ын оролцоогүйгээр шийдвэрлэх аргагүй гэсэн санаа дэвшүүлж, цохон тэмдэглэсэн байна.

Манай төвийн зохицуулах нарийн бичгийн дарга, дэд эрдэмтэн С.Ишдорж "Үндэсний дэвшил" сонины 1992 оны 2 ба 10 дугаар сарын дугааруудад "Кремлээс ногоон гэрэл ассаны дараа . . ." хэмээх судалгаа, сурталчилгааны томоохон өгүүлэл нийтлүүлж, ХХ зууны Монгол, Америкийн харилцааны түүхийн гол асуудлуудыг нарийвчлан нягталжээ. Хэрэв үзэл сурталжсан, намч улс төрийн дарангуйллын үед ХХ зууны эхний Америкийн дипломатч С.Сокобиныг тагнуул туршуул байсан гэж хэрдаж сэрдэж байсан бол С.Ишдорж түүний үйл ажиллагааг өөрөөр харж үнэлэх баримт гаргаж тавьжээ. Сокобин 1921 оны хувьсгалын дараа Монголд ирж Богд хаан, түүний засгийн газрын ерөнхий сайд Бодоо зэрэг удирдах албаны хүмүүстэй уулзаж, тус орны дотоод байдал, гадаад бодлоготой танилцаад "Монголчууд бол өөрийн түүх, соёлтой, хятадуудаас огт өөр үндэстэн юм" гэж байжээ. 1961 онд манай улсыг НҮБ-д гишүүнээр элсүүлэхэд ЗХУ шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсний дээр АНУ ч дэмжиж санал өгсөн тухай тодорхой дурдсан байна. Дэлхийн II дайны дараахнаас эхэлсэн "Хүйтэн дайны" бодлогын жилүүдэд Монгол, АНУ-ын хооронд удаан хугацаагаар албан ёсны харилцаа

тогтоолгүй явж ирсний гол шалтгаан нь "социалист, капиталист" хэмээгч хоёр систем"-ийн хоорондын цэрэг-улс төр, үзэл суртал, дипломат, эдийн засгийн зөрчил тэмцэл байсан бөгөөд үүнээс үүдэн Монголын тал ч "Социалист хамтын нөхөрлөлийн орнуудын гадаад бодлогын нэгдмэл чиг шугам" гэгчид захирагдан 1986 оны хавар Кремлээс "Ногоон гэрэл" асаахыг олон жил тэвчээртэй хүлээж байсанд оршино гэж С.Ишдорж цохон тэмдэглэжээ. Эцэст нь Монгол оронд шинээр бий болж байгаа ардчилал, зах зээлийн шинэтгэлийг АНУ аль болохоор дэмжиж, өөрийн зүгээс тусламж үзүүлэхийн зэрэгцээ эдийн засгийн бэрхшээл, хямралыг даван туулах, шилжилтийг амжилттай болгоход бусад улс орон, дэлхийн олон нийтийг татан оруулах талаар идэвхтэй ажиллаж, нааштай үр дүнд хүрээд байна гэсэн дүгнэлт хийжээ.

Монголын АНУ судлалын төвийн гишүүн, дэд эрдэмтэн А.Дамдинсүрэн "Дорно Өрнө" сэтгүүлийн 1991 оны гурав дахь дугаарт "Монгол, Америкийн харилцааны эхлэл" хэмээх өгүүлэл бичиж, ХХ зууны сүүлчээр Монголд томоохон хөрөнгөтөн орнуудын хөрөнгө нийлүүлсэн "Монгол-ор" (монгол алт) гэдэг пүүс байгуулагдахад Америк багагүй хөрөнгө оруулж, уул уурхайн 46 ижнөнөр ирүүлж ажиллуулж байсан тухай мэдээ баримт гаргаж тавьсан байна. 1910 онд Монгол дахь нөлөөний хүрээгээ хуваан тохиролцсны нууц гэрээ Орос, Японы хооронд байгуулагдсныг АНУ таашаасангүй, зарим төрөг арга хэмжээ авахыг оролдож байжээ. Тухайн үеийн Монголд ирж, байдалтай танилцсан америк иргэн Лондон Байтс нутагтаа буцаж очоод "Хятадад хүрэх оросын зам" хэмээх ном хэвлүүлсний дотор Монгол орныг тууш нэвтрэн гарах төмөр зам тавивал АНУ-аас Азийн гүнд орж худалдаа хийх боломж нээгдэх юм гэж тэмдэглэж байжээ. Нийслэл хүрээний баруунтаах Со гүнгийн хашаанд байрлаж байсан нэг орос дэлгүүрийн эзэн нь монголчуудаас ноос худалдан авч америк Рихардын пүүсэнд нийлүүлж байжээ. Богд хааны Засгийн газар АНУ-тай харилцаа холбоо тогтоохыг чухалчилж, Монголд ирж ажиллаж байсан америкийн харьяат швед худалдаачин Ф.Ларсэнд тэргүүн зэргийн тайж, гүнгийн зэрэг олгож, өөрийн төрийн дээд шагнал Эрдэнийн Очир одонгоор шагнаж байсан бөгөөд энэ тухай Ц.Цэрэн "Үнэн" сонинд нэн тодорхой бичсэн буй. Дамдинсүрэнгийн өгүүлэлд дурдсанчлан АНУ-ын нэрт дипломатч, төвд, монгол судлалын томоохон мэргэжилтэн В.Рокхиль Монголын байдалтай танилцахаар 1912 оны 12 дугаар сард Монголд хүрэлцэн иржээ. Оросын нийслэл Петербургт албан хэргээр очоод байсан ерөнхий сайд Намнансүрэн засгийн газартаа цахилгаан утас ирүүлж, "В.Рокхиль бол Далай ламтай сайн харилцаатай хүн тул хэрэв тэр хүн хүсвэл Богд хаантай уулзуулах хэрэгтэй" гэж захиж байжээ.

Эрдэмтэн Р.Чимэд "Өнөөдөр" сонины 1992 оны 9-10 дугаарт "Лууны яс" хэмээх өгүүлэл нийтлүүлснийхээ дотор Америкийн эрдэмтдээс эртний галавын амьтан судлаач доктор Вебстер Монголд анх удаа 1916 онд ирсэн бөгөөд монгол хэл сайн мэддэг байсан, түүний дэраа 1918, 1922-1930 оны

хооронд Г. Осборн, Р. Эндрюс нар тэргүүтэй 40 шинжээч бүхий геолог, палеонтолог, археолог, хүн судлалын томоохон шинжилгээний анги тэд үүрэг аан удаа Монголд ирж голдуу говийн аймгуудад судалгаа хийсэн хэдлэг нарийвчлан үзжээ. Тэд говиос 100 гаруй сая жилийн өмнө оршин амьдарч байсан үлэг гүрвэлийн чулуужсан араг яс, 20-оод өндөг, түүнчлэн мөн өндөгнийхөө хальсыг дөнгөж цоолоод цухуйн гарч байсан үлэг гүрвэлийн нялх зулзаганы чулуужмал нээж олж Монгол орныг дэлхий дахинд алдаршуулсан сонин явдал болжээ.

А. Дамдинсүрэн нэгэнт 1989 оны "Хөдөлмөр" сонины 9 дугаар сарын 25-ны өдрийн дугаарт "Монгол нутаг хүн үүссэн өлгий нутаг буюу" хэмээх өгүүлэл бичиж нийтлүүлсэн байх бөгөөд мөн сонины 1991 оны 7 дугаар сарын 21-31-ний өдрийн дугаарт "Монгол, Америкийн харилцааны тухайд" өгүүлэл хэвлэжээ. Тэдгээрийн дотор дурднаар Америкийн эрдэмтэн Ж. Лейди аль 1857 онд бичсэн зохиолдоо Монгол ерон бол хүн анх үүссэн газар байж болох тухай санааг анх дэвшүүлсэн ажээ. 1889 онд Америкийн эрдэмтэн А. Катржар "Хүн төрөлхөтний доторх арьстнуудын нийтлэг ерөнхий түүх" зохиолдоо "Төв Азийн хойд районуудад мичин анх хүн болж хувьссан нэгдмэл төв байж болох юм". Тэрхүү хүй нэгдлийн үеийн бүдүүлэг хүмүүс нь тэндээс манай гаригийн өмнөд халуун дулаан бүс рүү нүүдэллэн очоон" гэж бичиж байжээ. Дээр дурдсан америк эрдэмтэн Г. Осборн 1920-өөд оны үед Монголд хийсэн шинжилгээнийхээ үндсэн дээр тулгуурлан "Азийн халуун бүсэд биш, гагцхүү Төв Азийн умард хэсэг болох энэ нутагт л анхны хүний өвгийн ясны үлдэгдлийг эрэх хэрэгтэй" гэж бичжээ. Тэдгээр эрдэмтдийн дэвшүүлж байсан санаа, дүгнэлт, шинжлэх ухааны төсөөлөл нь нотлогдсон эсэхээс үл хамааран Америкийн шинжлэх ухаан Монгол орны талаар ихэд сонирхон, янз бүрийн судалгааг олон жилийн өмнө хийж байсан нь чухал байна. Осборн, Эндрюс нарын зэрэг эрдэмтэд "Америкийн Төв Азийн шинжилгээний ангийн Монголд хийсэн ажлын урьдчилсан тайлангийн эмхтгэл (1918-1929)" хоёр боть, "Монголын геологи", "Монголын эртний ургамал, амьтан", "Монголын археологи" гэх зэрэг 13 боть дөрвөтөй шинжилгээний бүтээл туурвиж, нүүрэн тал дээр нь англи нэрийн хамт монгол хэлээр орчуулан хуучин монгол бичгээр сайхангэгч дарм алдан халдсан монгол нэртэй хэвлүүлэн гаргасан нь монголын нүүдлийн иргэншилт соёлын уламжлалд гүн хүндэтгэлтэй хандаж байсныг гэрчилнэ. Америкийн Төв Азийн шинжилгээний ангийн болон бусад эрдэмтдийг манайд саяхан бол империализмын тагнуул төлөөлөгч, мэдлэг чадвараар мөхөс, ашиг хонжоо хайсан үл бүтэх этгээд хэмээн дүрсэлж харуулдаг байв. Дамдинсүрэн ийм алдас онолыг няцааж, тэдгээр эрдэмтэд гүн гүнзгий мэдлэгтэй, шинжлэх ухаанд нээлт хийсэн томоохон мэргэжилтэн нар байсан бөгөөд "Жинхэнэ эрдэм номын ариун цагаан буянт үйлсийн төлөө Монгол орныг сонирхон судлах" зорилгоор ирж байсан гэсэн дүгнэлтэнд хүрсэн байна.

Хүн судлалын хүрээлэнгийн ахлах ажилтан, нэрт сэтгүүлч

С.Жамбалдорж "Ардын эрх" сонины 1992 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн дугаарт "Америкийн тивийг монголчууд анх нээсэн..." гэсэн сонирхолтой өгүүлэл нийтлүүлжээ. Өгүүллийн эхний хэсэгт Америк тивд одоогоос олон арван мянган жилийн өмнөөс эхлэн Зүүн хойд Ази, Монгол орноос монголжуу төрхийн хүмүүс тухайн үед усанд авахуулаагүй, хуурай байсан Берингийн хоолойгоор дамжин очиж нутагшсан нь индиан нарын өвөг дээдэс мөн, тэд эцсийн эцэст Монголын говь нутгаас гарвалтай гэсэн Америк, Оросын эрдэмтдийн санаа, дүгнэлтийг улам тодруулан лавшруулж өгчээ. АНУ-ын Аляскийн хойг зэрэг нутгийн индиан газаруусны нэрсэлтэд "адак" (монголоор адаг), Ика-нүд (их нүд), Ика-нутаг (их нутаг), Ушки (уушиг), Уналга (уналга) гэх зэрэг монгол нэрс байгааг гярхай ажиглаж, монгол, америкийн эрдэмтэд энэ талаар хамтарсан шинжилгээ хийхийн чухлыг дурдатган сануулсан нь анхаарууштай зүйл юм.

Азитай ойр дөт байгаа Аляск байтугай алс тэртээ орших Латин Америкийн зарим орны индиан нарын дунд монгол хэл, заншилтай ихээхэн төсөөтэй зүйл байдаг. Перу, Боливын индиан нарын "аймара" хэмээх 1,4 сая хүн амтай нэгэн аймгийн нэр нь аймшигтай гэсэн утгатай, нүүр царай, биеийн галбир нь монголчуудтай тун төстэй бөгөөд хэл ярианд нь садан төрлийн хэсэг өрхийг айлю (монголоор айлуу), олон айлыг хотон-айлю (хот айлууд), орон сууцыг гар гэсэн нэр үгс үзэгдэнэ. Испанийн колоничлол эхлэхээс хэдэн үеийн өмнө байсан элэнц өвгийн нэр нь Манка (Мөнх) Капак байжээ. Колоничлолд автсан сүүлчийн хааных нь хан хөвгүүн Манко (Мөнх) колоничлогчдын эсрэг бослого гаргасан байх бөгөөд түүний үйл хэргийг үргэлжлүүлэн тэмцсэний хүний нэр нь Топак Амару (Амар) гэгддэг байжээ. Аймара хүмүүс уртын хэмжээг хуруу, төө, алдаар баримжаалдаг, нарны байршлаар цаг хугацааг төсөөлдөг, манайхны цай чанах зуур гэдэг шиг төмс ногоо болохын хооронд гэх мэтчилэн ярьдаг, тийнхүү төмс, ногоо чанахдаа улайсгасан чулуу хийж хорхоглон болгодог байна. Монголчуудтай ийм их төстэй аймаранууд хэзээ, хаанаас гараад ирсэн юм бол? Аймаранууд анх ХШ зууны үед түүхийн тэвцэн дээр гарч ирээд дараа нь Инкийн Их эзэнт гүрнийг үндэслэн байгуулсан байна. Эзэнт гүрэн байгуулаад тэд адуу малгүй байсан, боловч явган ертөө байгуулж ажиллуулж байжээ. Индианы янз бүрийн олон аймаг, өвгийн дундаас гагцхүү аймара аймгийн хэлэнд төмрийг нэрлэдэг тусгай үг байсач бөгөөд тэд төмөр хайлж эс чадавч түүнийг сайн мэддэг байжээ. Аймарайн өвөг дээдэс нь төмөр мэддэг газраас эзэнт гүрэн байгуулах ойлголт, чадвартай ирсэн монгол маагийн хүмүүс байгаад төмөргүй, хүрэл зэвсгийн нөхцөлд удал оршин амьдрахаас өөр аргагүй болсон байж бүрэн болох. Тэгвэл ХШ зууны үед Хувилай хаан монгол, солонгос, хятад цэргийг далайн хэдэн мянган хөлөг онгоцонд суулгаж Японы эсрэг дайнд хөдөлгөсөн, тэдгээр хөлөг онгоцууд Японд хүрмэгц далайн хар салхины хүчтэй шуурганд цохуулж, олонх нь усанд живж, цөөн хэд нь арай чарай буцаж ирээд хагас зарим нь ор сураггүй алга болсон байдаг. Ор сураггүй алга болсон хөлөг онгоцны нэг хэсэг нь далайн шуурганд хөөгдсөөр Перу, Боливын

нутагт хүрч газардаад тэдгээрийн дотор сууж явсан хүмүүс буцаж ирж чадалгүй үлдсний хойч үеийн удам угсааныхан нь аймарууд байсан юм биш байгаа? Аймарагийн хүний нэр, хэл яриа, зан заншилд Монголынхтой төстэй зүйл зонхилох боловч орон сууц барих, дүүжин гүүр тавих, ууланд усалгаатай шаталсан тариа тарих зэрэг нь хятад, солонгосынхтой төстэй зүйл байх шиг байна. Ямар боловч аймара аймгийг индианы нэг хэсэг болохынх нь хувьд америк судлалын үүднээс төдийгүй, монголчуудтай олон талаар онцгой холбогдол бүхий байж болохыг харгалзан монгол судлалын үүднээс газар дээр нь эрхбиш нэлээд нягтлан нэрийвчилж судлах шаардлагатай ч байж магад.

Америкийн эрдэмтэд өнөөгийн Монгол улсын өөрчлөлт шинэчлэлт, чөлөөт зах зээлд шилжих шилжилтийн арга замын холбогдолтой гярхай ажиглалт, нарийн шинжилгээ хийж байна. Зөвхөн ганц жишээ дурдахад доктор А. Кампи авгай 1992 оны 8 дугаар сард Улаанбаатар хотноо зохиогдсон олон улсын монголч эрдэмтдийн ээлжит 6 их хурал дээр "Монгол улс нүүдлийн социалист эдийн засгаа чөлөөт зах зээлд шилжүүлэн зохицуулахад учирч байгаа өвөрмөц бэрхшээлүүд" хэмээх илтгэл тавьж, нэлээд хэдэн чухал санаа, дүгнэлт дэвшүүлжээ. Түүний бодлоор бол Монгол улс зах зээлд шилжиж, эмч хувьчлахдаа Америк, Ази, Европын суурьшмал улс орон, өндөр хөгжилтэй улсын алиных нь ч загварыг махчлан хуулж болохгүй, тэр байтугай тийм улс орны зөвлөхүүдийн зөвлөж зааварласнаар замнахад учир дутагдалтай болно. Монгол орон бол угаасаа Төв Азийн хуурай, сэрүүн, эрс тэс уур амьсгалд зохицсон нүүдлийн мал аж ахуйн сонгодог орон байсаар ирсэн учир түүндээ тохирсон ихээхэн өвөрмөц загварын арга замыг гагцхүү өөрөө бүтээлчээр сэдэж олох хэрэгтэй, нүүдлийн мал аж ахуйгаа суурьшуулж үгүй хийх биш, хадгалан үлдэж, хайрлаж хөгжүүлэх нь зүйтэй гэнэ. Хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйг хувьчилмагц таваар үйлдвэрлэгч хувийн өмчтөн малчид шууд гарч ирээд зах зээлд өрсөлдөж чадахгүй, яагаад гэвэл малчид хот, суурингаас алс зайд амьдрах ба зам тээвэр, дэд бүтцийн гачаалаас болоод мал аж ахуйн бүтээгдэхүүнээ зах дээр хүргэж борлуулахад бэрх, шинэ бий болох хувийн аж ахуйтан чухамдаа таваар үйлдвэрлэгч биш, гол төлөв амиа аргацаасан айл ерх болно, тийм тархай бутархай хувийн аж ахуйтныг аж үйлдвэр, хот сууринтай улсын болон хувийн худалдаа, үйлчилгээгээр 1930-аад оны шинэ эргэлтийн бодлогын үеийнхтэйгээ адил төсөөтэй шуурхай холбож, шууд арилжаалан худалдаалах өвөрмөц арга хэлбэр хэрэглэж жинхэнэ зах зээл үүсгэн хөгжүүлэх шаардлагатай гэнэ.

Монгол орон зах зээлд шилжихдээ газар усыг хувьд эмчилдөггүй түүхэн уламжлал, нүүдлийн ахуй амьдрал, нүүдэл иргэншилд газрыг хувьд өмчлөх явдал огт таардаггүй учрыг ч анхаарвал зохино, тэр байтугай Монгол улс нь хувьсгалын жилүүдэд улсын аж үйлдвэр, сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдэл, улсын худалдаа, санхүүд түшиглэсэн өөрийн гэсэн бүхэл бүтэн эдийн засгийн тогтолцоо, түүний амьдэрч хөгжих өвөрмөц

механизм, онцлог арга хэлбэртэй болоод байсныг их л ухаалаг, учиртай задалж, юуг гээж, юуг авч үлдээн, юуг яаж өөрчилж шинэчлэхээ өөрийн орны уламжлал байдал, хэтийн төлөвтэй нягт уялдуулж шийдвэрлэх ёстой гэнэ. Энэ бүхнээс шалтгаалан "Монгол улс нь нүүдэлчин улс түмэн суурьшмал амьдрал, аж үйлдвэржилтэд шилждэг уламжлалт замыг салсан түүхийн сонирхолтой хувилбар олох уу, эсхүл энэ газар орон, ийм уур амьсгалд тэгэж сайхан зохисон нүүдлийн ажүй амьдралынхаа өөрийн шинж төрх дээр суурилсан зах зээлийн эдийн засгийн өвөрмөгц нэгэн загварыг хэрэг дээрээ үнэхээр бүтээж гаргаж ирэх чадвартай бийх нь уу гэдэг тухай асуудал үлдэж байна" гэсэн дүн шинжилгээг А. Кампи хийсэн байна.

Монголын Америк судлалд Америкийн Монгол судлалын зарим тал ийнхүү сонирхогдох ёстой болж байгажюм. Гэтэл Америкийн Зөвлөлт судлал, Орос судлал, Хятад судлалын зарим зүйл ч бидэнд бас сонирхолтой байж болох талтай.

Дээр дурьдсан бүх зүйлээс үзэхэд Монголын Америк судлалд шууд ба дам хамаарах асуудал цөөнгүй байх бөгөөд тэдгээрийн зөвхөн хагас заримыг ч гэсэн зохих ёсоор судлан боловсруулахад нэлээд тосны мэргэжлийн боловсон хүчин, багагүй хөрөнгө мөнгө шаардагдах нь ил харагдаж байна. Энэ байдлыг харгалзан Монгол улсын Үндэсний Их Сургуулийн Олон Улсын Харилцааны Дээд Сургуулийн удирдлага, манай хоёр төв санаачилж, тус сургууль дээр 1992 оны 11 дүгээр сард англи хэлний 2 дугаар ангийн 20-оод оюутнаас бүрдсэн америк судлалын сонгон суралцах анги нээн хичээллүүлж байна.

Эцэст нь, Монголын АНУ судлалын төв, Дорно Дахин, олон улс судлалын хүрээлэн, Олон Улсын Харилцааны Дээд Сургууль ба Монгол-Америкийн нийгэмлэг 1993 ондоо эхлэн жилдээ хоёр удаа гаргадаг Америк судлалын дундын нэг сэтгүүлтэй болох зорилт тавьж, ажлаа эхэлж байгаагийн баталгаа энэ гэдгийг хэлье.